



## НИЙТ ШҮҮГЧИЙН ЧУУЛГАНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журмыг хавсралтаар баталсугай.

ДАРГАЛАГЧ

Г.БАНЗРАГЧ

**ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ,  
ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР ТОМИЛОХ  
НИЙТЛЭГ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Бүх шатны шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход энэхүү нийтлэг журмыг баримтална.

Шүүх бүр энэ нийтлэг журамд нийцүүлэн, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.2.5-т заасны дагуу өөрийн нарийвчилсан журмыг батлан мөрдөж ажиллана.

1.2. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, санал, дүгнэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох журмыг тогтоохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 1) урьдчилан мэдэх боломжгүй;
- 2) тойрог дотор санамсаргүй тохиолдлоор;
- 3) ачаалал тэнцвэржүүлэх;
- 4) хуваарилагдсан болон хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөгдөх боломжгүй;
- 5) хүний нөлөөллөөс ангид;
- 6) ил тод;
- 7) баримтжуулсан байх;
- 8) шуурхай байх.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "хэрэг" гэж адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоолгон ирсэн хэрэг, прокуророос шилжин ирсэн эрүүгийн болон зөрчлийн хэрэг, прокуророос сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих санал гаргасан хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг, шүүгч, нийт шүүгчдээс татгалзаж ирсэн хэрэг, давж заалдах, хяналтын шатны шүүхэд хянуулахаар хүргүүлсэн хэрэг, дээд шатны шүүхээс шийдвэр нь хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүх өөрөө хянаж хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянаж, шийдвэр, тогтоолыг хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, нэгтгэж, тусгаарласан хэрэг, мөн шүүгчийн бүрэн эрх нь

дуусгавар болсон, эсхүл шүүгч удаан хугацаагаар эзгүй байгаа тохиолдолд бусад шүүгчдэд хуваарилах хэргийг ойлгоно.

1.3.2.“нэхэмжлэл” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2-т заасан нэхэмжлэл, 12.1.3-т заасан хүсэлт, 12.1.4-т заасан гомдол, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан өргөдлийг ойлгоно.

1.3.3.“өргөдөл, гомдол, хүсэлт” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4-т заасан гомдол, хүсэлт, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан өргөдөл болон өөрт хуваарилагдсан хэргийг хянан шийдвэрлэх тухайн шүүгчийн бүрэн эрхэд шууд хамаарах хүсэлтээс бусад Эрүү, Иргэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол, хүсэлт, арбитрайн өргөдөл, прокурорын санал, дүгнэлтийг ойлгоно.

1.3.4.“тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар” гэж тухайн тайлант оны шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаа ашиглан тогтоосон шүүгчдийн нэрсийн дараалал бүхий тойрог дотроос нэгдсэн системийг ашиглан санамсаргүй байдлаар сонгож хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахыг ойлгоно.

1.3.5.“хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл” гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, сургалтад хамрагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй (ажиллаагүй) байхыг ойлгоно.

### **Хоёр. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах**

2.1.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход хуульд заасан шаардлага хангасан программ хангамж ашиглана. Программ хангамжийн ажиллагаа болон аюулгүй байдлыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 71 дүгээр зүйлийн 71.1.12-т заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцна.

2.2.Нэгдсэн системд байрших тойрогт шүүгчдийн нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоож, нэгдсэн системд байршуулна.

2.3.Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

2.4.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид (CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт) хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

2.5. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээр хуваарилагдсан хэрэг, өргөдөл, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

2.6. Шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилахдаа доорх 3 аргыг ашиглаж болно.

2.6.1. "Ердийн журмаар хуваарилах арга" нь бусад 2 аргаар хуваарилах хэрэгт хамаарахгүй бүх төрлийн хэрэгт хамаарна.

2.6.2. "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга" нь хэргийн хавтас, яллагдагч, хэргийн оролцогч, шүүгчийн хүлээн авсан нэхэмжлэл, хэргийн тооноос хамаарна.

2.6.3. "Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга" нь хэргийн зүйлчлэл, маргааны төрлөөс хамаарна.

2.7. Хуваарилагдсан хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан шүүгч, бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, үндэслэл үүссэн, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилно. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг дахин хуваарилахдаа тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилах сонголтыг нэгдсэн системд тохируулсан байна.

2.8. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тухайн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд программд өөрчилсөн үндэслэл, шийдвэрийн талаар шаардагдах өгөгдлүүдийг оруулах бөгөөд энэ талаарх баримтын хувийг программ хангамж хариуцсан ажилтанд хадгалуулж, жил бүр архивд шилжүүлнэ.

### **Гурав. Шүүх бүрэлдэхүүнийг томилох**

3.1. Тухайн шүүхийн шүүгчдээс урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программ шүүх бүрэлдэхүүнийг сонгоно. Хоёр болон түүнээс дээш шүүх бүрэлдэхүүн зэрэг ажиллах тохиолдолд хэд хэдэн тойргийг үүсгэнэ.

3.2. Программ "тойрог дотор-санамсаргүй" горимоор шүүх бүрэлдэхүүн томилох хуваарилалт хийхдээ шүүгчдийн ачааллын тэнцвэрийг хадгална.

3.3. Томилогдсон шүүгч бүрэлдэхүүнд оролцох боломжгүй болсон тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөнөөс урьдчилан тогтоосон журамд заасны дагуу өөр шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд томилно.

3.4. Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөх үндэслэл болохгүй.

3.5. Адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах шүүгчийг томилохдоо энэ журмын 3.1-т зааснаар сонгоно.

## Дөрөв. Бусад

4.1. Ээлжийн амралтаа эдэлж эхлэхээс тодорхой хугацааны өмнө шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилалтыг зогсоохыг, ээлжийн амралтаа эдлээд ажилд ороход хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт тодорхой хугацааны өмнө хуваарилах эсэхийг тусгана.

4.2. Шүүгчид хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл бий болсон бол хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.3. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг, нэхэмжлэл хуваарилах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал тухай бүрд нь шүүгчдийн ээлжит бүс зөвлөгөөнийг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.

4.4. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор баталсан журмыг нэгдсэн системд тохируулахдаа шүүхийн тамгын газрын дарга, хэргийн хөдөлгөөн хариуцсан ажилтан, Ерөнхий шүүгчийн туслах нарын хяналтын дор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулна.

4.5. Энэхүү журмыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар олон нийтэд нээлттэй, шүүхийн цахим хуудсанд байршуулна.

4.6. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программын ажиллагаа, программ дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг хийх (screen recording) бөгөөд программд хандсан хэрэглэгчийн эрх, үйлдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь хадгалагдаж, тэдгээрт хөндлөнгийн хяналт хийгдэх боломжтой байна.

--oOo--